



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/309

Булган сум

Бүтээн байгуулалтын 2024-2025 онд хийгдсэн
ажилд хяналт тавих ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, 21.1.15, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн хэмжээнд 2024, 2025 онд улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээнд хяналт тавих ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид
(холбогдох сумдын)
Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
М.Цэрэнчимэд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)
Сумын Засаг дарга
Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн сум хариуцсан мэргэжилтнүүд
Н.Очирхуяг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
Нарийн бичгийн дарга: Г.Цолмон (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2.Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн чанар, үүрэг даалгаврын биелэлт, ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааны биелэлтийг заасан хугацаанд үр дүнтэй хамтран зохион байгуулж тухай бүрд үр дүнг танилцуулан, тайлан мэдээллийг гаргаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (О.Ундрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР